



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 19 өдөр


Дугаар A/19

Улаанбаатар хот

Г  
Сургалтын төрийн сангийн  
санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2013 оны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын “Журам батлах тухай” 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорждагва овогтой Мөнхзаяаг 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн АНУ-ын GALLAUDET-ийн их сургуульд англи хэлний дохионы хэлний багш, хэлмэрч, орчуулагчийн мэргэжлээр 2 жил бакалаврын сургалтад Сургалтын Төрийн сангийн зээлийн санхүүжилтээр суралцуулсугай.
2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР